



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

10
АНГИ

МОНГОЛ ХЭЛ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

Санамж:

- ✓ Монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын 23 даалгаврыг 40 минутад гүйцэтгэх тул цагаа сайтар төлөвлөж бүх даалгаврыг ажиллаарай.
- ✓ Монгол хэлний даалгавруудыг гүйцэтгэхдээ эхийг уншиж, сайтар ойлгосон байхыг анхаараарай.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Наран жанжин дохиолж байна (эсээ)

«Pater ejus est sol» (Эцэг чинь, Нар!)

Эртний латин хэлээр бичигдсэн “Маргад эрдэнийн толт гэдэг сударт “эцэг чинь, нар” гэсэн үг гардаг ажээ. Тэгвэл монголчууд “нар зөв эргүүлэгтэй хуй салхийг бурхны тоос” гэж бэлгэшээн “нар буруу эргүүлэгтэй хуйг” мангасын тоос хэмээн цээрлэдэг билээ. Орчлон хорвоо наран жанжны дохиурын дор нар зөв эргүүлгийн хөдөлгөөнөөр оршин ахуй бөлгөө. Нар буруу эрчилбээс эрч нь аажмаар суларч сульданд замхрахын тавилан эдэлдэг буюу.

2000 он бол Наран жанжны жил орж байгаа жин үдийн цаг. Арван нэгэн жил тутам наран дээр их халуун дөл буцалж галаар шуурдаг ажээ. Тэр нь түмэн түмэн жил нэг л хэмээр давтагдсаар бөгөөд давтагдах болгондоо наран авгай өөрөө улам турж, илч гэрэлд нь ээж, эргэн тойронд нь эргэлдэж буй гараг ертөнц болгонд уур амьсгалаараа нөлөөлдөг жамтай. Тэр жамыг хамгийн их амсдаг бяцхан гараг бол хүн төрөлхтний эзэгнэн суугаа дэлхий. Наран дээр дөл цацагдахад дэлхий дээр зүрх палхийдэг. Цас бороо орж, шуурга салхи дэгдэж, халуун хүйтэн сүлэлддэг. Тэр нь хүн амьтанд зүгээр өнгөрдөггүй үзэгдэл. Хүн төрөлхтний түүхийн урт замд тохиолдсон хэрэг явдлын хамгийн санамсаргүй бөгөөд огцом нь гагцхүү нарны дохио зангаатай холбоотойг эрдэмтэд ажиглаж нарийвчлан тодруулжээ. Хэн боловч нарнаас хараат гэдэг нь ойлгомжтой боловч сүүлчийн нэг хоёр зуун жилийн түүхэн баримтаас эш татан өгүүлбэл бүр ч тодорхой болох буй заа. Зөвхөн өнгөрсөн зууныг аваад үзэхэд нарны жил орж идэвхжих бүрийд хувьсгал гарч байжээ. Үүнд:

...1967-1968 онд АНУ-д негрүүдийн хөдөлгөөн, Хятадад соёлын хувьсгал болж Прагад үймээн дэгдэв.

1979-1980 онд Иранд хувьсгал, Никарагуад хувьсгал тус тус гарч, Афганистанаас зөвлөлтийн цэрэг гарав.

1989-1991 онд Орост Горбачев, коммунист нам унаж, дэлхийд эдийн засгийн хямрал гарав. Монголд ардчиллын хөдөлгөөн өрнөв.

1999-2001 онд Югослав, Чеченийн дайн, хоёр Солонгосын асуудал, эдийн засгийн хэсэгчилсэн хямрал гарч байгаа бөгөөд АНУ-ын Нью-Йорк дахь Олон улсын худалдааны төвийн хоёр өндөр байшинг онгоцоор дайрч сөнөөв. Цаг агаарын гэнэтийн өөрчлөлтүүд нүүрлэв.

Ийнхүү арван нэгэн жил тутамд нарны идэвхжил урд хойноо нэг нэг жилийн удиртгал юм уу үдэлттэйгээр давтагдаж хүн ардын сэтгэл санаагаар зогсохгүй байгаль дэлхийн үзэгдэл юмсын тэнцвэр алдагдахад хүрэх гэнэтийн тохиолдлуудтай нүүр тулгардаг нь бараг л зүй ёсны “бичигдээгүй хууль” мэт болсон нь хамгийн нийтлэг хэдхэн баримт дурдахад маш тодорхой харагдаж байна.

“Нарны идэвхжил” гэж яг юуг хэлж байгааг одоо үед мэдэхгүй хүн ховор биз. Гэхдээ нарийвчлан яривал наран дээр олон тооны толбо гарч дэлбэрэлт үүсэх, үүнд 1957 оны ээлжит нарны юм үзэгдэх үеэр 263 толбо үүссэн нь нарны тослог идэвхжилийг судлах болсноос хойш тохиолдсон хамгийн олон тоот цоохортол юм. Мөн онд туйлын туяа 203 удаа үзэгдсэн нь бас л рекорд хэмжээ байжээ. Тэр жилийг угтаад наран дээр протоны дэлбэрэлт болсон нь устөрөгчийн мянган бемор тэсэлсэнтэй тэнцэхүйц тийм их эрчим хүч ялгаруулан, гадагш нь тухайлбал манай

дэлхий рүү цацсан гэсэн үг юм. Газрын холд тэр нь цуцаж хөрөх хэдий боловч ямар нэгэн хэсэг нь дэлхийн бөмбөрцөгт тусаж л таардаг байна. Туссан тэр нь хэчнээн бага байлаа ч гэсэн ор мөргүй өнгөрч чадахгүй ажээ. “Нарны толбо үүсэх үйлдлийн оргил үе шиг улс орны удирдагчид, цэргийн жанжид, уран илтгэгчид, хэвлэл мэдээлэл болон бусдын нөлөө үлэмжхэн их хүчтэй болдог тийм цаг үе байдаггүй. Тийм үед цагийг нь олж хэлсэн ганц үг юм уу дохио зангаа нь бүхэл бүтэн армийг, ард олныг хөдөлгөж чаддаг” гэж наран биологийн ухааныг үндэслэгчдийн нэг Александр Чижевский бичжээ. Нарны идэвхийн оргил үед олон түмэн хөдөлгөөн хүсэж, цэргүүд болохоор барьж зогсооход бэрхтэйгээр бослого гаргах, ард олон болохоор анархист байдалд орох хандлагатай болдог. Манай дэлхийд бүхэлдээ биш ч гэсэн тодорхой бүс нутагт олон төрлийн гэнэтийн явдлууд тохиох нь гарцаагүй. Юу болохыг би мэдэхгүй. Харин хэзээ болохыг мэдэж байна!” гэж наран биологийн их эрдэмтэн Чижевскийн бардам хэлсэн нэг үг бий.

Нарны идэвх нэмэгдэх тусам дэлхийн соронзон талбай хуйлран тавгүйтэж түүний балгаар хүмүүст зүрх судасны өвчин, мэдрэлийн хямрал гарах шалтгаан болох тул эрүүл мэндийн тэнцвэрийг хангах урьдчилсан арга хэмжээг авах шаардлагатай юм. Нөгөөтээгүүр газар тариалан, агаарын болоод усан замын аяллын хувь заяанд шууд хамааралтай Наран жанжны дохиоллыг урьдчилан мэдэж байх нь элдэв осол цалгар байдал, гэнэтийн тохиолдлоос сэрэмжлэн, олон хүний амь насны аюулгүй байдлыг хангахад чухал болой. Наран жанжин хатуурах мөчлөгийнхөө оргилд очиж байгааг бүү марттугай!

Л.Түдэв, 2000 он

Монгол хэлний даалгаврууд

1. “Нарны идэвхжил давтагддаг” гэсэн санааг илэрхийлэх эсээний толгой өгүүлбэрийг олоорой.
 - A. “Нарны идэвхжил” гэж яг юуг хэлж байгааг одоо үед мэдэхгүй хүн ховор биз.
 - B. Арван нэгэн жил тутам наран дээр их халуун дөл буцалж галаар шуурдаг ажээ.
 - C. Тэр жамыг хамгийн их амсдаг бяцхан гараг бол хүн төрөлхтний эзэгнэн суугаа дэлхий.
 - D. Наран дээр дөл цацагдахад дэлхий дээр зүрх палхийдэг.
2. Эсээний сэдвийг олоорой.
 - A. Нар зөв эрчлэх тухай
 - B. Нарны идэвхжилтийн нөлөөний тухай
 - C. Монголчуудын цээрийн тухай
 - D. Нар буруу эрчлэх тухай
3. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэр аль вэ?
 - A. Эртний латин хэлээр бичигдсэн «Маргад эрдэнийн толт гэдэг сударт «эцэг чинь, нар» гэсэн үг гардаг ажээ.
 - B. Монголчууд «нар зөв эргүүлэгтэй хуй салхийг бурхны тоос» гэж бэлгэшээн «нар буруу эргүүлэгтэй хуйг» мангасын тоос хэмээн цээрлэдэг.
 - C. Орчлон хорвоо наран жанжны дохиурын дор нар зөв эргүүлгийн хөдөлгөөнөөр оршин байдаг ажээ.
 - D. Нар буруу эрчилбээс эрч нь аажмаар суларч сульдан замхрахын тавилан эдэлдэг буюу.

4. “Арван нэгэн жил тутам наран дээр их халуун дөл буцалж галаар шуурдаг ажээ” гэсэн санааг батлах түүхэн баримтыг сонгоорой.
- A. Юу болохыг мэдэхгүй. Харин хэзээ болохыг мэдэж байна.
 - B. 1979-80 онд Иранд хувьсгал, Никрагуад хувьсгал тус тус гарч, Афганистанаас зөвлөлтийн цэрэг гарав.
 - C. Мөн онд туйлын туяа 203 удаа үзэгдсэн нь бас л рекорд хэмжээ байжээ.
 - D. 2000 он бол Наран жанжны жил орж байгаа жин үдийн цаг.
5. “Үүнд 1957 оны ээлжит нарны юм үзэгдэх үеэр 263 толбо үүссэн нь нарны тослог идэвхжилийг судлах болсноос хойш тохиолдсон хамгийн олон тоот цоохортол юм” гэсэн баримтын хэлбэрийг зөв тодорхойлсныг олоорой.
- A. Наран дээрх толбоны тоон үзүүлэлтийг онцолсон учраас тоон баримт
 - B. Наран дээр үүссэн толбо бодитой байсан учраас бодит байдлын баримт
 - C. Наран дээрх толбыг судалсан учраас судалгааны баримт
 - D. Наран дээр толбо үүсдэг шалтгааныг таамагласан учраас таамагласан баримт
6. “Юу болохыг би мэдэхгүй. Харин хэзээ болохыг мэдэж байна!” хэмээн наран биологийн их эрдэмтэн Чижевскийн бардам хэлсэн үгийн талаар Тэргэл, Эрдэнэ хоёр ярилцаад санал зөрөлдөв. Учир нь Тэргэл эрдэмтэнтэй санал нэгтэй байсан бол Эрдэнэ харин эргэлзсэн. Тэгвэл дараахаас аль нь Тэргэлийн үзэл бодол вэ?
- A. “1830 онд зургаадугаар сарын хувьсгал, 1848 онд хоёрдугаар сарын хувьсгал” гэсэн баримтууд яг 11 жилээ барихгүй байна шүү дээ.
 - B. Нарны дэлбэрэлтийн үнэмлэхүй хүчин чадал нь дэлхийд сул нөлөөтэй байдаг гэсэн дээ.
 - C. 2020-2022 онд дэлхий нийтэд “корона” вирус дэгдэж, Орос Украины дайн эхэлсэн шүү дээ.
 - D. Наран жанжин гэж юу билээ? Нар чинь зүгээр л нар биз дээ?
7. “Ийнхүү арван нэгэн жил тутамд нарны идэвхжил урд хойноо нэг нэг жилийн удиртгал юм уу үдэлттэйгээр давтагдаж хүн ардын сэтгэл санаагаар зогсохгүй байгаль дэлхийн үзэгдэл юмсын тэнцвэр алдагдахад хүрэх ... хамгийн нийтлэг хэдхэн баримт дурдахад маш тодорхой харагдаж байна.” гэсэн өгүүлбэрийн “ийнхүү” гэх холбох үгийн үүргийг тодорхойлоорой.
- A. нөхцөлдүүлэн холбох
 - B. угсруулан холбох
 - C. лавшруулан холбох
 - D. эсрэгцүүлэн холбох
8. “Цас бороо орж, шуурга салхи дэгдэж, халуун хүйтэн сүлэлддэг.” гэсэн өгүүлбэрт байгаа таслал(.) -ууд ямар үүргээр орсон бэ?
- A. орж, дэгдэж гэсэн үйлүүд цаг хугацааны дарааллаар хүүрнэснийг тэмдэглэх үүрэгтэй
 - B. цас, шуурга гэсэн үзэгдлүүдийг нэг цагт зэрэгцүүлэн тоочсоныг тэмдэглэх үүрэгтэй
 - C. орж, дэгдэж гэсэн үйлүүд нэг цагт зэрэгцүүлэн тоочсоныг тэмдэглэх үүрэгтэй
 - D. цас, шуурга гэсэн үзэгдлүүдийг цаг хугацааны дарааллаар хүүрнэснийг тэмдэглэх үүрэгтэй

9. “Тийм үед цагийг нь олж хэлсэн ганц үг юм уу, дохио зангаа нь бүхэл бүтэн армийг, ард олныг хөдөлгөж чаддаг” гэсэн өгүүлбэрийн санааг хэлцээр илэрхийлээрэй.
- олон хэлбэл улиг, цөөн хэлбэл билиг
 - голыг нь олж хэлэх
 - үг олдож, үхэр холдох
 - ганц үг ган хийхгүй
10. “Нөгөөтээгүүр газар тариалан, агаарын болоод усан замын аяллын хувь заяанд шууд хамааралтай Наран жанжны дохиоллыг урьдчилан мэдэж байх нь чухал” өгүүлбэрийн “нөгөөтээгүүр” гэсэн холбох үгийг ойролцоо утгатай холбох үгээр солин найруулаарай.
- Өөрөөр хэлбэл
 - Мөн түүнчлэн
 - Түүнчлэн
 - Басхүү
11. “Наран биологийн их эрдэмтэн Чижевскийн бардам хэлсэн нэг үг бий” гэсэн өгүүлбэрийг хүндэтгэлийн найруулгатай өгүүлбэр болгон бичсэн нь аль вэ?
- Наран биологийн их эрдэмтэн Чижевскийн бардам хэлсэн нэг үг бий.
 - Наран биологийн их эрдэмтэн Чижевскийн бардам айлдсан нэг үг бий.
 - Наран биологийн их эрдэмтэн Чижевскийн бардамнаж хэлсэн нэг үг бий.
 - Наран биологийн их эрдэмтэн Чижевскийн бардам хүүрнэсэн нэг үг бий.

Үндэсний бичгийн даалгаврууд

12. Үндэсний бичгээр бичсэн өгүүлбэрийг зөв уншаарай.

- Хаан хүний гучин таван эрдмийн дотор Хайрлах сэтгэл нэн эрхэм.
- Хаан хүний гучин таван эрдмийн доор Хайрлах сэтгэл нэн эрхэм.
- Хаан хүний гучин таван эрэнийн дотор Хайрлах сэтгэл нэн эрхэм.
- Хаан хүний гучин таван эрдмийн дотор Хайрлах сэтгэл нэн эрхэм.

13. Хувилах үсгээр төгссөн үгийг олоорой.

A.

B.

C.

D.

14. Хувилгагч толгойт бүлэг нөхцөлийг олоорой.

A.

B.

C.

D.

15. “ᠬᠤᠲᠤᠭ” хэмээх өвөрмөц бичлэгтэй үгийг кириллээр зөв хөрвүүлснийг олоорой.

A. хутаг

B. хундага

C. худаг

D. Хутга

16. “ᠠᠨᠳᠠᠭ” гэсэн үгийн “-дуи” бүтээвэр нь.....

- аад гэсэн нөхцөлийн утгыг илтгэнэ
- д гэсэн нөхцөлийн утгыг илтгэнэ
- үгүй гэсэн үгийн утгыг илтгэнэ
- аандаа гэсэн үгийн утгыг илтгэнэ

Уран зохиолын даалгаврууд

17. Монголын нууц товчоо зохиол нь “уран зохиолын дурсгал” болохыг аль хэсгээр баталж болох вэ?
- A. Ширмэн төмөр магнайтай, Шивээ хурц хэлтэй, Ган төмөр зүрхтэй, Гадас цүүцэн хошуутай, Галзуу дөрвөн нохой
 - B. Хаан эзэндээ халдсан харц ардыг ураг төрлий нь хүртэл устга" гэж зарлиг болов. Тэгээд Жамухын нүдний өмнө түүнд халдсан ардыг алав.
 - C. Барс жил (1206) Онон мөрний эхэнд хуралдаж, есөн хөлт цагаан тугаа мандуулаад Тэмүжинд Чингис хаан (Далай хаан) цолыг өргөв.
 - D. "Улс төрийг байгуулалцсан урьдын гавьяат нөхдөө угсаатан ноёд болгож, мятралгүй зүтгэсэн миний хайрт нөхдийг мянганы ноёд өргөмжлөв.
18. МНТ-нд Есүй хатан:
“...Уул мэт бие чинь
Нурж одвол
Улс орон Монголыг чинь
Хэн захирах юм бэ?...” гэж хэлдэг ба үүгээр Есүй хатны сэтгэлийн ямар өнгө аяс илэрч байна вэ?
- A. гэмшсэн
 - B. гомдсон
 - C. дургүйцсэн
 - D. зовнисон
19. МНТ зохиолд “Тэр өвөл өвөлжиж, нохой жилийн (1202 оны) намар, Чингис хаан, цагаан татаар, алчи татаар, тутауд татаар, алухай татаар нартай Далан нэмүргэ гэдэг газар байлдахын урьд Чингис хаан, цааз тогтоож зарлав” гэж гардаг. Тэгвэл тэрхүү цаазад юу гэж захирамжилсан байдаг вэ?
- A. "Дайсныг дарах цагт олзонд бүү саатагтун. Дайсан нэгэнд дарагдвал тэдний юм хэзээд бидний олз болох тул хуваалдаж амжина. Хэрэв бид ухрахад хүрвэл анх довтолсон байрандаа даруй эгж ирвэл зохино. Уг байрандаа эгж ирээгүй хүнийг алтугай"
 - B. "Аль ч зүгээс ямар ч дайсан ирэх магадгүй, есөн сайд минь гурван хэсэг болж яв" гэж зарлиг болов. Хэрэв бид ухрахад хүрвэл анх довтолсон байрандаа даруй эгж ирвэл зохино.
 - C. "Дайсан хэрэв халдаж ирвэл бид хатгалдан байлдах билээ. Дайсан тийнхүү дутаасан бол бид цэргээ засацгааж нэхье" гэж хөдлөв.
 - D. "Хэрэв дайсан халдаж ирвэл байлдъя". Уг байрандаа эгж ирээгүй хүнийг алтугай"
20. МНТ-ны “Өдөр үзэх нүд, шөнө сонсох чих болгох” гэсэн хэсэгт уран дүрслэлийн ямар арга байна вэ?
- A. егөөдөл
 - B. ихэсгэл
 - C. төлөөлөл
 - D. багасгал

Санамж:

- ✓ Хоёрдугаар хэсэг харгалзуулах даалгавар тул хариултын хуудасны 2-р хэсэгт зааврын дагуу будаж тэмдэглээрэй.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1 Хүснэгт дэх мэдээлэл баримт уу, үзэл бодол уу? Зөвийг сонгож тэмдэглээрэй.

№	Мэдээлэл нь	Баримт	Үзэл бодол
a	Монгол бичгийг төрийн бичиг болгох сэргээн хэрэглэх бүх нийтээрээ эзэмших тухай бүхий л шатанд ихэд ярьж хэлэлцсээр байгаа боловч үр дүн нь ханалттай бус байна.	1	2
b	Еврей хэл Англиар hebrew оросоор еврей, еврит \ичих\ симит язгуурын хэл. Израйл улсын албан ёсны хэл бөгөөд 7 сая гаруй хүн хэлэлцдэг.	1	2
c	Монгол бичгийн хэрэглээ 1990-ээд оныхоо байранд зогссоор байна гэхэд хилсдэхгүй.	1	2
d	Энэ нь монгол бичгийнхээ сайн мууд байгаа биш үндэстний сэтгэлгээ, идэвх, эх оронч үзэл, өөрийгөө хамгаалах зөн зэрэг зүйлээс хамааралтай юм.	1	2
e	МЭӨ 3 дугаар зууныг хүртэл Палестин орчимд хэлэлцэгдэж байгаад зөвхөн бичгийн хэл болж үлдсэн боловч 19 дүгээр зуунаас ахин амьд ярианы хэл болон сэргэсэн түүхтэй.	1	2

2.2. Өгүүлбэрүүдийг дүрслэх ур маягтай нь зөв харгалзуулаарай.

- a Олон дайнд оролцон чадал хүчиндээ эрдэж явснаа санахад чиний илдийн дор явж би хэзээ ч чадахгүй. 1 Адилтгал
- b Үндэс мөчир бөхтэй Хорхоногийн саглагар мод шиг цэцэглэн ганхаж явсан юм сан. 2 Амьдчилал
- c Тэр газрын цээжийг аниртан чагнаваас монгол эрсийн нөхөрлөл, гунигт хагацлын тухай эмгэнэлт түүхийг өгүүлнэ. 3 Хэтрүүлэл
- d Тунгалаг мөрөн зөөлөн зөөлнөөр дув дуугүй урсах дор 4 Төлөөлөл
- e Ялгуун саарал морин нь тогтож ядан, гуа сайхан дөрвөн хөлөөр ээлжлэн газар цавчилж, уран сайхан толгойгоо ийш тийш сэжихүй нь агаар дор дэгдэж, үүлэн дор умбан алдана. Д.Нацагдорж “Хөдөө талын үзэсгэлэн”

2.3 Монгол бичгийн дүрс ялган бичсэн үгсийг зөв харгалзуулаарай.

- a 1 сэтгэх /бөглөө гаргах/
- b 2 сэтгэх /бодох/
- c 3 шийтгэх
- d 4 сэтгэл